

ЕВРОПЫН СЭРГЭЭН БОСГОЛТ, ХӨГЖЛИЙН БАНК

Эрсдэл хуваалцах зээлийн шугам (RSF) – Хаан Банкны бүх хөрөнгөөр барьцаалсан зээлийн шугам

Улс	Монгол
Төслийн дугаар	47819
Бизнесийн салбар	Барьцааны мөнгөний зээл (Банк)
Мэдэгдлийн төрөл	Хувийн
Байгаль орчны ангилал	FI
Зөвлөлийн хурлын тов	2015 оны 9 дүгээр сарын 30
Статус	Эцсийн үнэлгээнд тэнцсэн. Зөвлөлөөр батлуулах гэж байгаа
Төслийн холбогдолтой мэдээллийг ил болгосон	2015 оны 7 дугаар сарын 29

Төслийн товч танилцуулга

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) Монголын Хаан банкинд 60 сая америк долларын санхүүжилт олгох асуудлыг судалж байна.

Энэхүү санхүүжилтын шугам нь:

- (i) Үнэ өсөн нэмэгдэх сүлжээний санхүүжилт ("VCF") бүхий хувийн бичил, жижиг, дунд үйлдвэрийн газар ("MSMEs"- БЖДҮГ)-т дамжуулан зээлдэхэд зориулсан 30 сая хүртэлх америк долларын тэргүүлэх зээл;
- (ii) Монголын Тогтвортой эрчим хүчний санхүүжилтын шугам ("MonSEFF")-ын хүрээнд улс орон дахь тогтвортой эрчим хүчний төслийн санхүүжилт хийхэд зориулсан 10 сая хүртэлх америк долларын эрчим хүчний үр ашигтай байдал ("EE")-ыг сайжруулах зээл;
- (iii) Дотоодын хувийн MSMEs-т урт хугацааны санхүүжилт олгоход зориулсан 10 сая хүртэлх америк долларын, бүх хөрөнгөөр барьцаалсан, эрсдэл шууд хуваалцах зээлийн шугам ("RSF");
- (iv) Арилжааны санхүүжилтын хязгаар (лимит)-ыг 10 сая америк доллар хүртэл нэмэгдүүлэх;

эдгээрээс бүрдэнэ.

Энэхүү арга хэмжээ нь Монгол дахь үндсэн бизнесээ өргөжүүлэх, санхүүжилтын бүтцээ сайжруулах боломжийг Хаан банкинд олгох юм.

Шилжилтийн үеийн нөлөө

MSME/VCF зээл нь хувийн БЖДҮГ-т, түүний дотор Улаанбаатараас гадуур байгаа БЖДҮГ-т зориулсан урт хугацааны санхүүжилтын олдцыг нэмэгдүүлэх замаар зах зээлийн тэлэлтэд хувь нэмэр оруулах юм. Үнэ өсөн нэмэгдэх сүлжээний санхүүжилт (VCF)-ын хэсэг нь дотоодын зах зээлд нэвтрүүлж эхлээд байгаа ийм бүтээгдэхүүнээ улам өргөжүүлэхэд нь Хаан банкинд дэмжлэг болох юм.

Эрчим хүчний үр ашигтай байдал (EE)-ыг сайжруулах зээл нь Монголын Тогтвортой эрчим хүчний санхүүжилтын шугам (MonSEFF)-ын хоёр дахь дэд төсөл бөгөөд эрчим хүчний үр ашигтай байдлыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтын ач холбогдлыг эергээр харуулах, эдийн засагт шинээр бий болж буй бүтээгдэхүүнийг сурталчлах, мөн тогтвортой эрчим хүчний салбар дахь Хаан банкны зээлийн чадавхийг бий болгоход хувь нэмэр оруулах болно. Тус Банк нь тогтвортой эрчим хүчний хөрөнгө оруулалтын клиент (үйлчлүүлэгч) талын эрсдэл, зээл авах чадавхийг үнэлэх чадвар (экспертиз) хуримтлуулах бөгөөд эрчим хүч тогтвортой хэмнэх чадавхи бүхий клиентийг таньж илрүүлэх чадвараа сайжруулах юм. Техник хамтын ажиллагаа (ТС)-ны шугамаар дэмжлэг үзүүлэх дамжуулан зээлдэгч талуудын хувьд өөрийн үйл ажиллагаанд нь Тогтвортой эрчим хүчний хөрөнгө оруулалтын үзүүлэх техник, санхүүгийн үр ашгийн талаар мэдэж авах ач холбогдолтой байх юм.

Эрсдэл хуваалцах зээлийн шугам ("RSF") нь Хаан банкны зүгээс хувийн хэвшлийн том болон дунд хэмжээний үйлчлүүлэгчдийнхээ зээл авах хэрэгцээг урт хугацаанд хангах боломжийг нэмэгдүүлэх замаар Монголын банкны салбар дахь өрсөлдөөнийг цаашид эрчимжүүлэх болно.

Худалдааг дэмжих хөтөлбөр (TFP)-ийн хязгаар (лимит)-ыг нэмэгдүүлсэн нь Хаан банкны хувийн хэвшлийн үйлчлүүлэгчдийнхээ худалдааг санхүүжүүлэх, экспорт, импортын үйл ажиллагааг нь өргөжүүлэх ажилд дэмжлэг болох юм. Тус Төслөөр бодит эдийн засагт шууд үр ашиг өгөх худалдааг хөхиүлэн дэмжих юм.

Үйлчлүүлэгч

Хаан банк нь зах зээлд нийт хөрөнгөөр 23%, зээлийн хэмжээгээр 24% тус тус эзэлдэг Монголын хамгийн том арилжааны банкнуудын нэг юм. Тус банк нь нийт 500 гаруй салбараараа дамжуулан олон улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж, улс орныхоо өнцөг булан бүрт хүрч ажиллаж байна.

ЕСБХБ-ны санхүүжилт

10 сая хүртэлх америк доллар

Төслийн өртөг

60 сая хүртэлх хөрөнгийг америк доллароор гаргана

Байгаль орчин, нийгмийн ангилал, нөлөө болон саармагжуулалт

Санхүүгийн байгууллага (ESP 2008) хэмээх ангилалд багтдаг Хаан банк нь ЕСБХБ-ны байнгын үйлчлүүлэгч бөгөөд Үйл ажиллагааны шаардлагын 2, 9 дүгээр зүйл ангийн шаардлагыг үндсэнд нь хангасан «Байгаль орчны бодлого, байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны процедур» баримт бичиг батлан гаргасан болно. Хаан банк өөрийн байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны процедураа ЕСБХБ-ны санхүүжилтээр олгох БЖДҮГ-т олгох зээл, дамжуулан

зээлдэх ажиллагаандаа баримтлах, дамжуулан зээлдэгчид нь байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, хөдөлмөрийн стандартын үндэсний шаардлагыг хангасан байх явдлыг хангах ёстой. Дээр нь, эрчим хүчийг үр ашигтай болгох чиглэлийн зээлээр санхүүжилт авч буй дамжуулан зээлдэгч нар Эрчим хүчний үр ашгийн төслүүдэд тавигдах шалгууруудыг хангасан байх ёстой. Хаан банк нь Үйл ажиллагааны шаардлагын 2, 9 дүгээр зүйлийн нөхцлийг тогтмол хангаж, байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны шаардлага хангасан тайланг жил тутам гаргаж танилцуулах үүрэгтэй.

Техникийн хамтын ажиллагаа

Хаан банк нь 2008-2012 онуудад Монголд олгох олон талт банкны зээлийн шугамын хүрээнд БЖДҮГ-ын зээлд зориулсан техник тусламж авч (БЖДҮГ-ын зээл, лизингийн 2 сая долларын тусламжийг санхүүгийн түнш нийт байгууллагаас авсан) ирсэн. Санхүүжилтыг ЕСБХБ-ны Шилжилтийн эхэн шатанд яваа орнуудад зориулсан сан, ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сангаас олгож байв.

Тус Банк мөн Хамтран санхүүжүүлэх дунд хэмжээний зээлийн шугам (MCFF)-аас техник тусламж авч байсан. MCFF нь үйл ажиллагаа явуулахаар сонгогдсон орнууд дахь дунд хэмжээний компаниудад санхүүжилт олгох иж бүрдэл хэрэгслүүдийн бүрэлдэхүүн хэсэг болгон байгуулагдсан шугам юм.

ЕСБХБ Монгол дахь үнэ өсөн нэмэгдэх сүлжээний санхүүжилт (VCF) хэрэгжүүлэх боломж, үр ашгийг тооцоолсон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулсан болно. ЕСБХБ нь энэхүү судалгаанд Хаан банкныг хамруулж, түүний орон даяарх хамгийн том сүлжээг ашигласан. Энэхүү техник хамтын ажиллагааг ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сангаас санхүүжүүлсэн болно.

Одоогийн үйл ажиллагааны техник хамтын ажиллагаа:

Эрчим хүчний үр ашгийг сайжруулах зээл (EE)

Хаан банкинд олгож буй Эрчим хүчний үр ашгийг сайжруулах зээл нь Монголын Тогтвортой эрчим хүчний санхүүжилтын шугам ("MonSEFF")-ын хүрээн дэх 1,4 сая евроны үнэ бүхий техник хамтын ажиллагааны хөрөнгөөс гарах бөгөөд ЕСБХБ-ны Хувьцаа эзэмшигчдийн тусгай сангаас санхүүжих юм.

Энэхүү техник хамтын ажиллагааны санхүүжилтээр шаардлага хангасан тогтвортой эрчим хүчний төслүүдийг тодруулж үнэлэх, тогтвортой эрчим хүчний зээл олгох, маркетинг хийх Хаан банкны чадавхийг бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

Эрсдэл хуваалцах зээлийн шугам ("RSF") нь Шилжилтийн эхэн үеийн орнууд (ETC)-ын хандивлагчдын хамтын сангаас дэмжлэг үзүүлэх төслүүдийн хэрэгцээнд тулгуурласан дамжуулан зээлдэх зээлийн асуудлаар техник хамтын ажиллагаа хэрэгжүүлэхэд хөрөнгө гаргах үүрэгтэй байх юм. Үүнээс гадна,

Эрсдэл хуваалцах зээлийн шугам ("RSF") нь түнш банкны үнэлгээ хийх, баримт бичиг боловсруулах ажилд техник тусламж үзүүлэх боломжийг агуулж байгаа.

Компаний холбоо барих ажилтан, хаяг

Б. Болортуяа – Хөрөнгө оруулалтын газрын ахлах ажилтан

Хаан Банк, ХХК

Сүүл гудамж-25, Ш/х #192, Улаанбаатар, Монгол Улс

И-мэйл: bolortuya.b@khanbank.com

Вэбсайт: www.khanbank.com

Утас: +976 11 332 333 Факс: +976 70 117 023

Бизнес боломжууд

Бизнес боломж болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

Ерөнхий мэдээлэл

ЕСБХБ-ны худалдан авалттай холбоогүй төслүүдийн талаархи мэдээллийг дорхи хаягаар лавлана уу:

Утас: +44 20 7338 7168; Факс: +44 20 7338 7380

И-мэйл: projectenquiries@ebrd.com

Нийтийн мэдээллийн бодлого (PIP)

ЕСБХБ өөрийн стратеги, бодлого, үйл ажиллагаагаа бусдад илүү сайн хүртээх, ойлгуулах зорилгоор мэдээллийг хэрхэн ил тод болгодог, сонирхогч талуудтайгаа хэрхэн зөвлөлддөг талаар Нийтийн мэдээллийн бодлого (PIP) гаргасан. Энэ тухай мэдээллийг <http://www.ebrd.com/pages/about/what/policies/pip.shtml> хаягаар авч болно.

Төслийн холбогдолтой гомдол хүлээн авах механизм (PCM)

ЕСБХБ нь тус Банкны санхүүжилттэй төслүүдээс үүдэн хохирол учирч байгаа, учирч болзошгүй гэх хувь хүмүүс, байгууллагын аливаа гомдлыг хараат бусаар хянан үзэх боломжтой Төслийн холбогдолтой гомдол хүлээн авах механизм (PCM) бий болгосон.

Тус механизмын ажиллах журмыг <http://www.ebrd.com/documents/occo/project-complaint-mechanism-pcm-rules-of-procedure.pdf> хаягаар орос хэл дээр үзэж болно.

ЕСБХБ-ны санхүүжилт олгосон хугацаанаас хойш зөвхөн 12 сарын дотор холбогдох гомдол өргөдлийг Гомдол хүлээн авах механизмын журмын дагуу гаргасан байх ёстой. Ийм механизм хариуцсан ажилтантай pcm@ebrd.com хаягаар холбогдоно уу. Хэрэв та гомдол гаргах холбогдох хугацааны талаар эргэлзэж байгаа бол ЕСБХБ-ны холбогдох Суурин төлөөлөгчийн газартай холбоо барина уу.